



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 09 сарын 15 өдөр

Дугаар 1/132

Чингис хот

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.1 "б", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5, 58 дугаар зүйлийн 58.2.20, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.16 дахь заалт, Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын "Аймгийн 2021 оны төсөв батлах тухай" 2020 оны 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.5 дахь зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор "Чадварлаг багш" арга хэмжээний хүрээнд дүрслэх урлагийн суурь боловсролыг мэргэжлийн багшгүй эзэмших боломжийг сурагчдад олгох, сурлагын хоцрогдлыг арилгах, дүрслэх урлагийн боловсролыг шинэ түвшинд ахиулах санаачлага болон багшийн мэргэжил арга зүйн хөгжлийг дэмжин лаборатори Хэрлэн 1 дүгээр сургуулийн технологийн багш Ч.Батзаяагийн мэдлэгт суурилсан бүтээлийг хэвлэхэд дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэгт шаардагдах 3,000,000 (Гурван сая) төгрөгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-т, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Г.Лхагвахатан)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ц.ИДЭРБАТ



• 231010043